

ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2014 оны 8-р сарын 27-ны байдлаар*


2014 оны 8-р сарын 27-ны байдлаар хүнсний гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 3.6 хувь, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 0.7 хувиар буурсан байна.

Махны дундаж үнэ: 2014 оны 8-р сарын 27-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сарынхаас 7.5 хувь, үхрийн ястай махны үнэ 5.1 хувь, үхрийн цул махны үнэ 11.4 хувь, адууны махны үнэ 12.8 хувь, ямааны махны үнэ 9.8 хувиар буурсан байна.

Өмнөх 7 хоногийнхтой харьцуулбал үхрийн ястай махны үнэ 0.3 хувь, үхрийн цул махны үнэ 1.1 хувь, ямааны махны үнэ 0.2 хувь, хонины ястай махны үнэ 1.8 хувь, адууны махны үнэ 1.5 хувиар буурсан байна.

2014 оны 8-р сарын 27-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 6495 төгрөг, үхрийн /ястай/ мах 7550 төгрөг, үхрийн цул мах 8685 төгрөг, адууны мах 5475 төгрөг, ямааны мах 5590 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).


Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ



Гурилын үнэ: 2014 оны 8-р сарын 27-ны байдлаар өмнөх сарынхаас дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ 0.3 хувь, дээд зэргийн савласан гурилын үнэ 0.4 хувиар буурч, 1-р зэргийн гурилын үнэ 2.0 хувь, 2-р зэргийн гурилын үнэ 8.7 хувиар өссөн байна. Харин өмнөх 7 хоногийнхоос гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2014 оны 8-р сарын 27-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй, элсэн чихрийн үнэ өмнөх сарынхаас 2.4 хувиар өсч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна (Зураг2).

Зураг2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2014 оны 8-р сарын 27-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ өөрчлөлтгүй, манжингийн үнэ 31.2 хувь, луувангийн үнэ 31.8 хувь, сонгины үнэ 0.8 хувь, байцааны үнэ 17.5 хувиар буурсан байна.

Өмнөх 7 хоногийнхоос манжингийн үнэ 9.7 хувь, луувангийн үнэ 8.6 хувиар буурчээ.

Сүү, өндөг, ургамлын болон цэцгийн тосны дундаж үнэ: 2014 оны 8-р сарын 27-ны байдлаар өмнөх сарынхаас савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.5 хувь, “Элекстер” /0.5 л/ савласан сүүний үнэ 2.0 хувь, задгай сүүний үнэ 9.1 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сарынхаас 0.2 хувиар өссөн бол, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна. Өндөгний үнэ өмнөх сарынхаас 5.6 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй, цэцгийн тосны үнэ өмнөх сарынхаас 1.0 хувиар өсч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

**ҮСХ-ны Макро эдийн засгийн статистикийн газар
2014 оны 8-р сарын 27**